





ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


Аудитын дэлгэрэнгүй тайланг <https://audit.mn/>

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн орлого, зардал




Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлого 15 хувиар тасарсан нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бодитой төлөвлөөгүйгээс шалтгаалжээ.




Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зардал 56.2 хувийн хэрэгжилттэй байгаа нийт орлого тасарсан, Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 83.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлээгүй нь голлох нөлөө үзүүлжээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын төрийн албан хаагчийн тоо



Орон нутгийн төсвийн байгууллагын төрийн албан хаагчийн тоо 2024 онд 890 байснаас 2025 онд 985 болж 95 албан хаагчаар нэмэгдсэн нь тайлант онд 2 байгууллага шинээр байгуулагдсан, хот тохижуулах газарт 45 албан хаагч нэмэгдсэн нь шалтгаалсан байна.

Орон нутгийн төсвөөс олгож буй орон нутагт ажилласны нэмэгдлийг 2023 онд улсын төсвийн 17 байгууллагад 1.0 тэрбум, 2024 онд 85 байгууллагад 6.5 тэрбум, 2025 онд 85 байгууллагад 13.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгожээ.



■ Олгосон санхүүжилт тэрбум ₮
■ ТШЗ тоо

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргад:

- Орон нутгийн төсвөөс олгож буй орон нутагт ажилласны нэмэгдэл цалингийн санхүүжилтийг санхүүгийн жил дуусахаас өмнө тооцоо нийлж, үлдэгдлийг тайлант онд багтаан барагдуулж байх.
- Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолд тусгагдсан “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ.” гэсэн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.
- Аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хөтөлбөр, арга хэмжээний хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж байх.
- Гадаад арга хэмжээний зардлын хяналтыг сайжруулж, батлагдсан хөтөлбөр, хүрэх үр дүнтэй уялдуулж, хэмнэлттэй байдлаар зарцуулах.

